

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2023/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2023 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал.....	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
6. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	27

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

Ал. 17 № 12

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ"-ИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ш.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант хугацаанд бүрдүүлсэн нэмэлт орлого буюу байр болон залны түрээсийн 28,298.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэхдээ гэрээний дагуу авлага үүсгээгүй, хүлээн авсан мөнгөн дүнгээр орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дахь заалт, УСНББОУС 9-д заасан "14. Орлогыг хүлээн авсан буюу хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. 15. Ажил гүйлгээнээс үүсэх орлогын дүнг тухайн байгууллага ба түүний хөрөнгө, үйлчилгээг худалдан авагч буюу хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээгээр ихэвчлэн тодорхойлдог" стандартын заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэж 14,311.2 мянган төгрөгийн 24 гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв

008020043

толилуулах ёстой" стандартын заалттай нийцэхгүй, ангилал батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Оюутан суралцагчдаас дадлагын хувцасны төлбөр нийт 12,240.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар бүртгэж зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.1.1, 3.1.2 дахь заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>311,945,811.08</u>	<u>367,747,421.48</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	12,798,271.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	12,798,271.00
3121	Төгрөг	00.00	12,798,271.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	12,798,271.00
33	АВЛАГА	9,090,170.00	13,309,841.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,640,170.00	2,182,841.40
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,280,000.00	6,280,000.00
335	Бусад авлага	1,170,000.00	4,847,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,677,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,170,000.00	1,170,000.00
34	УРЬДЧИЛГАА	8,001,865.00	5,879,179.00
3471	Урьдчилгаа тооцоо	8,001,865.00	5,879,179.00
34713	Цалингийн урьдчилгаа	8,001,865.00	5,879,179.00
35	БАРАА МАТЕРИАЛ	294853776.08	335760130.08
354	Хангамжийн материал	294,853,776.08	335,760,130.08
35410	Бичиг хэргийн материал	896,000.00	501,000.00
35420	Аж ахуйн материал	288,616,705.57	324,645,155.57
35460	Хүнсний материал	5,341,070.51	10,613,974.51
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,223,109,459.19</u>	<u>4,052,840,286.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,223,109,459.19	4,052,840,286.68
392	Биет хөрөнгө	4,015,067,209.19	3,844,873,036.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,898,012,275.23	3,898,012,275.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-356,323,427.28	-475,097,903.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,502,075.00	71,502,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-71,502,075.00	-71,502,075.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,466,705,495.20	2,486,373,906.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,144,018,723.38	-2,205,107,431.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	393,018,789.00	399,055,761.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-301,638,137.75	-318,675,209.55
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,166,666.83	-9,166,666.85
39217	Ном	47,477,605.00	49,478,305.00
393	Биет бус хөрөнгө	208,042,250.00	207,967,250.00
39301	Програм хангамж	9,090,995.00	9,090,995.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,984,745.00	-9,059,745.00

39303	Бусад биет бус хөрөнгө	209,886,000.00	209,886,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,950,000.00	-1,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,535,055,270.27</u>	<u>4,420,587,708.16</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9,729,053.12</u>	<u>22,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,729,053.12	22,000.00
413	Өглөг	9,729,053.12	22,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,237,653.12	00.00
4136	Бусад өглөг	491,400.00	22,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	491,400.00	22,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,525,326,217.15</u>	<u>4,420,565,708.16</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,525,326,217.15	4,420,565,708.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,681,905,393.60	3,681,905,393.60
51101	Өмч: - төрийн	3,681,905,393.60	3,681,905,393.60
512	Хуримтлагдсан үр дүн	91,421,059.86	-13,339,449.13
51210	Өмнөх үеийн үр дүн	91,421,059.86	91,421,059.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-104,760,508.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	751,999,763.69	751,999,763.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,535,055,270.27</u>	<u>4,420,587,708.16</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,999,610,383.84	2,793,938,498.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,426,583.84	170,710,198.00
120	Нийтлэг татварын бус орлого	58,426,583.84	170,710,198.00
120003	Торгуулийн орлого	00.00	765,990.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,426,583.84	169,944,208.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,846,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,179,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	51,401,583.84	169,944,208.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,941,183,800.00	2,623,228,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,893,147,500.00	1,853,490,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,893,147,500.00	1,853,490,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,036,300.00	53,993,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,036,300.00	53,993,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	715,745,200.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	715,745,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,384,749,726.91	2,898,699,006.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,384,749,726.91	2,898,699,006.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,330,625,429.11	2,729,233,479.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,176,739,190.91	1,301,195,566.99
210101	Үндсэн цалин	830,840,661.91	821,465,156.52
210102	Нэмэгдэл	282,546,854.40	357,595,906.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,063,895.00	60,779,433.00
210104	Урамшуулал	36,287,779.60	61,355,071.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,875,995.12	162,821,707.70
210201	Тэтгэврийн даатгал	108,607,495.12	114,666,370.93
210202	Тэтгэмжийн даатгал	10,639,500.00	12,185,247.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,234,400.00	9,514,682.75
210204	Ажилгүйдлийн даатгал	2,308,600.00	2,311,410.99
210205	Эрүүл мэндийн даатгал	23,086,000.00	24,143,995.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	377,270,300.00	631,692,627.87
210301	Гэрэл, цахилгаан	23,198,390.00	24,472,770.87
210302	Түлш, халаалт	337,188,410.00	532,052,977.00
210303	Цэвэр, бохир ус	16,883,500.00	75,166,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	102,073,202.10	61,247,040.00
210401	Бичиг хэрэг	14,202,576.00	32,219,665.00
210402	Тээвэр, шатахуун	5,229,730.00	10,347,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,047,458.00	4,939,975.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,566,200.00	6,420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,971,791.00	7,320,100.00
210408	Бараа материал акталсны зардал	61,055,447.10	00.00
2105	Нормативт зардал	47,115,427.00	86,294,321.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,633,020.00	1,590,978.00
210502	Хоол, хүнс	42,482,407.00	69,740,343.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	14,963,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,432,744.20	61,251,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,669,900.00
210602	Тавилга	8,080,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,624,500.00
210604	Урсгал засвар	39,352,744.20	55,957,500.00
2107	Томилолт, зочны зардал	288,000.00	2,678,400.00
210702	Дотоод албан томилолт	288,000.00	2,678,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,225,680.00	9,895,915.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,902,500.00	3,106,600.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.00	2,016,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,779,780.00	2,751,315.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,500.00	211,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,400.00	65,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	401,500.00	1,746,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	414,604,889.78	412,156,000.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,290,000.00	29,763,520.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	402,314,889.78	382,392,480.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,124,297.80	169,465,527.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,439,046.00	115,783,650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	29,371,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,812,546.00	83,192,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,626,500.00	3,220,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	685,251.80	53,681,877.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	685,251.80	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-385,139,343.07</u>	<u>-104,760,508.99</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-385,139,343.07</u>	<u>-104,760,508.99</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,948,208,800.00</u>	<u>2,636,026,571.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,025,000.00	12,798,271.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,025,000.00	12,798,271.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,025,000.00	12,798,271.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,179,000.00	12,798,271.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,941,183,800.00	2,623,228,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,893,147,500.00	1,853,490,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,893,147,500.00	1,853,490,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,036,300.00	53,993,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,036,300.00	53,993,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	715,745,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	715,745,200.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,944,340,056.00	2,577,372,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,944,340,056.00	2,577,372,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,890,215,758.20	2,407,906,672.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,154,994,360.00	1,316,965,094.67
210101	Үндсэн цалин	691,783,747.00	834,233,427.75
210102	Нэмэгдэл	337,338,663.40	352,353,178.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,722,050.00	60,779,433.00
210104	Урамшуулал	70,149,899.60	69,599,055.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,917,220.00	167,179,499.54
210201	Тэтгэврийн даатгал	109,745,220.00	119,024,162.77
210202	Тэтгэмжийн даатгал	11,543,000.00	12,185,247.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,234,400.00	9,514,682.75
210204	Ажилгүйдлийн даатгал	2,308,600.00	2,311,410.99
210205	Эрүүл мэндийн даатгал	23,086,000.00	24,143,995.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	377,270,300.00	631,692,627.87
210301	Гэрэл, цахилгаан	23,198,390.00	24,472,770.87
210302	Түлш, халаалт	337,188,410.00	532,052,977.00
210303	Цэвэр, бохир ус	16,883,500.00	75,166,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,304,544.00	32,520,640.00
210401	Бичиг хэрэг	4,476,956.00	4,775,365.00
210402	Тээвэр, шатахуун	4,518,330.00	8,372,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,047,458.00	4,939,975.00
210404	Ном, хэвлэл	-	521,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,466,200.00	6,420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,795,600.00	7,492,000.00
2105	Нормативт зардал	41,694,610.00	95,257,225.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,971,020.00	1,590,978.00
210502	Хоол, хүнс	32,661,390.00	75,013,247.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,062,200.00	18,653,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,470,144.20	68,038,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,467,500.00	29,766,600.00
210602	Тавилга	11,249,400.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	940,900.00	7,462,550.00
210604	Урсгал засвар	54,812,344.20	30,809,800.00
2107	Томилолт, зочны зардал	288,000.00	2,678,400.00
210702	Дотоод албан томилолт	288,000.00	2,678,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,465,680.00	9,895,915.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,902,500.00	3,106,600.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.00	2,016,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,779,780.00	2,751,315.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,500.00	211,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,400.00	65,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	401,500.00	1,746,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	240,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,810,900.00	83,678,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,810,900.00	83,678,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,124,297.80	169,465,527.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,439,046.00	115,783,650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	29,371,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,812,546.00	83,192,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,626,500.00	3,220,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	685,251.80	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	685,251.80	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	53,681,877.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,868,744.00</u>	<u>58,654,371.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>1,944,340,056.00</u>	<u>2,577,372,200.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,880,000.00	45,856,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,880,000.00	45,856,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,880,000.00	45,856,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,880,000.00	45,856,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,880,000.00)</u>	<u>(45,856,100.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>1,944,340,056.00</u>	<u>2,577,372,200.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(11,256.00)	12,798,271.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,256.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,798,271.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,569,235,300.00	2,517,754,457.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,569,235,300.00	2,517,754,457.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,450,568,000.00	2,403,170,807.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,354,255,600.00	1,316,755,094.67
210101	Үндсэн цалин	909,247,000.00	834,023,427.75
210102	Нэмэгдэл	321,574,700.00	352,353,178.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,284,000.00	60,263,433.00
210104	Урамшуулал	70,149,900.00	69,599,055.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,182,100.00	167,179,499.54
210201	Тэтгэврийн даатгал	121,010,100.00	119,024,162.77
210202	Тэтгэмжийн даатгал	11,543,000.00	12,185,247.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,234,400.00	9,514,682.75
210204	Ажилгүйдлийн даатгал	2,308,600.00	2,311,410.99
210205	Эрүүл мэндийн даатгал	23,086,000.00	24,143,995.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	631,634,400.00	631,633,337.87
210301	Гэрэл, цахилгаан	34,073,800.00	24,472,770.87
210302	Түлш, халаалт	503,957,700.00	531,993,687.00
210303	Цэвэр, бохир ус	93,602,900.00	75,166,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,868,400.00	29,596,440.00
210401	Бичиг хэрэг	4,806,200.00	4,775,365.00
210402	Тээвэр, шатахуун	4,072,100.00	4,072,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,945,600.00	4,939,975.00
210404	Ном, хэвлэл	2,621,900.00	2,521,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,819,600.00	6,420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,603,000.00	6,867,100.00
2105	Нормативт зардал	88,854,800.00	82,196,475.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,591,000.00	1,590,978.00
210502	Хоол, хүнс	80,940,000.00	74,282,497.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,323,800.00	6,323,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,064,500.00	810,242,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	57,067,100.00	56,562,000.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,954,900.00	7,462,550.00
210604	Урсгал засвар	17,042,500.00	17,017,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,006,100.00	1,973,000.00
210702	Дотоод албан томилолт	2,006,100.00	1,973,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,712,700.00	5,816,190.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.00	2,016,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,782,000.00	1,778,190.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495,000.00	211,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	65,000.00	65,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,006,700.00	1,746,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	348,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,989,400.00	86,978,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	86,989,400.00	86,978,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,667,300.00	114,583,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	118,667,300.00	114,583,650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,360,000.00	29,371,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	83,192,800.00	83,192,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,114,500.00	2,020,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,569,235,300.00	2,517,754,457.08
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,853,490,100.00	1,802,037,547.17
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,853,490,100.00	1,802,037,547.17
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	715,745,200.00	715,716,909.91
132001	Орон нутгийн төсвөөс	715,745,200.00	715,716,909.91
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	83.00	79.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	52.00	49.00
620003	Үйлчлэх ажилтан	30.00	29.00
620004	Гэрээт ажилтан	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,473,969,393.60	00.00	2,434,213,815.04	00.00	5,908,183,208.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,473,969,393.60	00.00	2,434,213,815.04	00.00	5,908,183,208.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,005,616,816.73	00.00	1,005,616,816.73
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	91,421,059.86	00.00	4,525,326,217.15
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	91,421,059.86	00.00	4,525,326,217.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	91,421,059.86	00.00	4,525,326,217.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-104,760,508.99	00.00	-104,760,508.99
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	-13,339,449.13	00.00	4,420,565,708.16

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,036,300.00	51,791,965.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,036,300.00	51,791,965.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,332,630.00	51,791,965.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	692,160.00	210,000.00
210101	Үндсэн цалин	692,160.00	210,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,520.00	-
210201	Тэтгэврийн даатгал	86,520.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		59,290.00
210302	Түлш, халаалт		59,290.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,781,130.00	4,924,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,781,130.00	4,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		624,900.00
2105	Нормативт зардал	4,724,020.00	13,060,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,724,020.00	-
210502	Хоол, хүнс		730,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		12,330,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,146,300.00	26,791,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,350,000.00	13,000,000.00
210602	Тавилга	11,249,400.00	-
210604	Урсгал засвар	4,646,900.00	13,791,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,902,500.00	4,079,725.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,902,500.00	3,106,600.00
210803	Даатгалын үйлчилгээ		973,125.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	760,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		760,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,626,500.00	1,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,626,500.00	1,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,626,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,200,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,170.00	-
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	77,170.00	-

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,036,300.00	51,791,965.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,036,300.00	51,791,965.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,036,300.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		51,791,965.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн эрхэм зорилго нь “Дэвшилтэт технологи инновацыг хөгжүүлэгч сургууль болох” юм. 2022 онд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

- Байгууллагын соёл, ёс зүйг төлөвшүүлэх
- Оюутан суралцагчийн хөгжил, олон нийтийн ажилд сайн дураар оролцох, зохион байгуулах дадал хэвшлийг төлөвшүүлэх
- Хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, төгсөгчийн мэдлэг ур чадварыг олон улсын түвшинд дүйцүүлэн үнэлэх, тооцох баталгаажуулах
- Сургалтын шаталсан тогтолцоог бий болгох, сургууль хоорондын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, суралцагчдын ур чадварын зөрүүг арилгаж сургалтын чанарыг дээшлүүлэх
- Сургалтын хөтөлбөрийг ХЗЗ-ийн эрэлт шаардлагад нийцүүлэх, ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн индексийг нэвтрүүлэх
- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлэх, гомдол саналыг цахимаар хүлээн авч шийдэх

Дээрх зорилтын хүрээнд ТЕЗ-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт 42 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 90.8%-тай дүгнэгджээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн дотоод аудитын чиг үүрэг бүхий бүтэц байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 114,467.6 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	12,798.3	12,798.3
Авлага	17,092.0	19,189.0	2,097.0
Бараа материал	294,853.8	335,760.1	40,906.3
Үндсэн хөрөнгө	4,223,109.5	4,052,840.3	-170,269.2
Нийт хөрөнгө	4,535,055.3	4,420,587.7	-114,467.6
Өр төлбөр	9,729.1	22.0	-9,707.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,525,326.2	4,420,565.7	-104,760.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,535,055.3	4,420,587.7	-114,467.6

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгө засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 12,798.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ахмадын сан үүсгэснээс шалтгаалжээ.
2. Авлага дансны үлдэгдэл 2,097.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 12 дугаар сард худалдан авсан үндсэн хөрөнгө биетээр ирээгүй тул байгууллагаас авах авлага үүсгэснээс шалтгаалсан байна.
3. Бараа материал дансны үлдэгдэл 40,906.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 11, 12 дугаар сард хангамжийн материалын дансанд үйлдвэрлэлийн дадлага хийх материал худалдан авснаас шалтгаалжээ.
4. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 170,269.2 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд: төсвийн хөрөнгө худалдаж авсан 45,865.1 мянга, оюутан сурагчдын хандиваар худалдаж авсан ор 9,200.0 мянга, үнэ шинэчилж тогтоож дахин үнэлсэн 33 хөрөнгө 160,744.2 мянга, нийт 215,809.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. ТӨБЗГ-ын 2022 оны 709 дүгээр тогтоолоор 184,417.2 мянган төгрөгийн 85 ширхэг үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.
5. Засгийн газрын хувь оролцоо данс өмнөх оноос 104,760.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,247,746.3 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 8,500.0 мянга, нийт 2,256,246.3 мянга, зарлагыг 2,256,246.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орлого, зардлыг 62,148.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, оны эхэнд 2,318,394.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 250,841.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж жилийн эцэст 2,569,235.3 мянган төгрөг болгож тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71804 хөтөлбөрийн 80101 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,654,332.8 мянга, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 715,745.2 мянга, 80802 арга хэмжээг санхүүжүүлэхээр 118,667.3 мянга, 81806 арга хэмжээг санхүүжүүлэхээр 80,490.0 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,802,037.5 мянга, орон нутгийн төсвөөс 715,716.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,517,754.5 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 51,480.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

11, 12 дугаар сард 557,899.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан ба нийт санхүүжилтийн 22 хувийг эзэлж байна. 12 дугаар сард 45,865.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бичиг хэрэг, хангамжийн материал 44,485.6 мянга нийт 90,350.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71804-80101	1,654,332.8	1,613,171.4	41,161.4	97.5
2	71804-80112	715,745.2	715,716.9	28.3	99.9
3	71804-80802	118,667.3	114,583.7	4,083.6	96.6
4	71804-81806	80,490.0	74,282.5	6,207.5	92.3
Нийт		2,569,235.3	2,517,754.5	51,480.8	98.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд байр, залны түрээсийн орлого 28,298.0 мянга, оюутан сурагчдаас хураасан орлого 14,485.0 мянга, сургалтын орлого 3,265.0 мянга, БОАЖГ-аас модны урамшуулал 7,240.0 мянга, цахим тендерийн орлого 105.0 мянга, бусад орлого 600.0 мянга, нийт 53,993.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, оюутан сурагчдын дадлагын хувцас худалдан авах зардалд 12,330.0 мянга, гэнэтийн ослын даатгалын төлбөрт 973.1 мянга, тоног төхөөрөмжийн зардалд 13,000.0 мянга, шатахууны зардалд 4,100.0 мянга, урсгал засварын зардалд 9,473.3 мянга, сургалтын зардалд 4,170.0 мянга, тэтгэмжийн зардалд 1,200.0 мянга, бусад зардалд 6,545.6 мянга нийт 51,792.0 мянган төгрөгийг зарцуулж, 2,201.0 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа материал, шатахууны тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Анхтуяа гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн 12 дугаар албан бичгээр 2 хоног хугацаа хоцроож ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүн 2,384,749.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,847.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэр, цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 4

зарлагын гүйлгээ, 1 орлогын гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан мэдээлээгүй нийт 29,079.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8, 6.8.2, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.13, 2.2.2.2, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.2.10, 3.2.11 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тулган баталгаажуулалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүйгээс 13,816.8 мянган төгрөгийн зөрүү үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягт зааврын НХМаягт ТМ-5 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулж албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний 3-р улирлын байдлаар хийсэн завсарын аудитаар өгсөн 3,985.5 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	555.0	1	555.0	100%
Албан шаардлага	10	668,534.4	10	574,939.6	86%
Зөвлөмж	3	1,900.0	2	1,900.0	90%
Нийт дүн	14	670,989.4	13	577,394.6	92%

Өмнөх аудитаар 670,989.4 мянган төгрөгийн 14 зөрчил илрүүлж, 577,394.6 мянган төгрөгийн 13 зөрчилд албан шаардлага, 555.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 1,900.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар

хэрэгжилтийг хянаж үзэхэд албан шаардлага 86% , төлбөрийн акт 100%, зөвлөмж 90%-тай хэрэгжсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

11, 12 дугаар сард 557,899.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан ба нийт санхүүжилтийн 22 хувийг эзэлж байна. 12 дугаар сард 45,865.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бичиг хэрэг, хангамжийн материал 44,485.6 мянга нийт 90,350.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Оны эцэст их хэмжээний санхүүжилт хуваарилж байгаагаас шалтгаалан тендергүй худалдан авалт хийх, их хэмжээний нөөц үүсгэх, оны эцэст хийгдсэн хөрөнгийн худалдан авалт тайлант онд биетээр ирэхгүй байх зэрэг эрсдэл үүсэх шалтгаан болж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,079.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс завсрын аудитаар 3,985.5 мянга, аудитын явцад 17,093.5 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

1. Ээлжийн амралтыг цалин хөлстэй давхардуулан 3,219.5 мянган төгрөгийг /Илүү, дутуу/ олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй
2. Сахилгын шийтгэлийн суутгал 766.0 мянган төгрөгийг орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой" стандартыг баримтлаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй
3. Нярав үндсэн хөрөнгийн тайланг данс тус бүрээр бэлтгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС-17.52-д "Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба хэрэглээ бүхий хөрөнгүүдийн бүлэг" стандартыг баримтлаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй
4. 12,798.2 мянган төгрөгийн ахмадын сан үүсгэсэн боловч харилцах дансанд үлдэгдлийг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой" стандартыг баримтлаагүй, ангилал батламж мэдэгдлийг хангаагүй
5. 12 дугаар сард нийт 34,980.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан боловч 3,677.0 мянган төгрөгийн хөрөнгө бүрэн хүлээж аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.6 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС 17.89-д "Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгийн анги тус бүрийн хувьд мөн дараах зүйлсийг санхүүгийн тайланд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

тодруулна: в) Үндсэн хөрөнгийг худалдан авах талаархи гэрээний хариуцлагын дүн стандартыг баримтлаагүй

6. Татварын тайланд 618.3 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.7 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" стандартыг баримтлаагүй, ангилал батламж мэдэгдлийг хангаагүй

Аудитаар нийт 60,021.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 4,364.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 55,674.6 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 4 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

6.1 Төлбөрийн акт

- 5.1.1. Нийт 5 ажилтанд 1 хоногийн томилолт илүү, 1 ажилтанд захирлын цохолтгүй, засвартай томилолтын хуудсаар 156.0 мянган төгрөгийн томилолтын зардал бодож олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.4, 2.8 дахь заалтууд, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 5.1.2 Нийт 136 оюутан суралцагчдаас цахим сургалтад хамруулах зорилгоор 2,720.0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд оруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулсан

Энэ нь Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.1.1, 3.1.2 дахь заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 5.1.3 Жолоочийн тооцооны хуудсанд явсан ирсэн зай тодорхойгүй, норм хэтрүүлсэн, спидометрийн заалт давхардуулсан, анхан шатны баримтгүй нийт 1,470.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4" дахь заалтууд, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Албан шаардлага

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.1. Нийт 136 оюутан суралцагчдаас нэг хүний 90.0 мянган төгрөг нийт 12,240.0 мянган төгрөгийн төлбөр хурааж, дадлагын хувцас худалдан авахдаа нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж зарцуулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.1.1, 3.1.2 дахь заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2.2. НДШ-ийн тайланд 825.4 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.7 дахь заалтуудыг зөрчсөн, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2.3 Тооцооны дансаар дамжуулаагүй, орлогод аваагүй, 24 буюу 14,311.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, шууд зардалд бүртгэсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" стандарттай нийцэхгүй, ангилал батламж мэдэгдлийг хангаагүй байна.

5.2.4 Байр болон залны түрээсийн орлогыг бүртгэхдээ гэрээний дагуу авлага үүсгээгүй, хүлээн авсан мөнгөн дүнгээр 28,298.0 мянган төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 9-д "14. орлогыг хүлээн авсан буюу хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. 15. Ажил гүйлгээнээс үүсэх орлогын дүнг тухайн байгууллага ба түүний хөрөнгө, үйлчилгээг худалдан авагч буюу хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээгээр ихэвчлэн тодорхойлдог" стандарттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2.5 НББ тайлагнал хангалтгүй, шилэн данс, цахим бүртгэлийн системийн алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.9, Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2, МУЕА-ын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан "Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай" хавсралтын 3.1.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

5.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд ашигласан болон ажиллагсдад түгээн хуваарилсан хангамжийн материал дансанд бүртгэлтэй 191 нэр төрлийн бараа материалыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.7, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтууд, УСНББОУС-Бараа материал 12-44, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагаанд ашиглаж байгаа, ажиллагсдад түгээн хуваарилсан бараа материалыг данснаас хасаж, эд хөрөнгө ашиглалтын бүртгэлээр хяналт тавих

2. Бараа материалын бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсанд тухайн байгууллагын автомашин нь ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг бичээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4” дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсанд ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг тодорхой бичих, хэдэн км зарцуулснаа хянаад гарын үсэг зурах, нягтлан бодогч тооцоог хийж шатахууны хэтрэлт хэмнэлтийг гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Ээлжийн амралтыг цалин хөлстэй давхардуулан олгосон байна. / Илүү, дутуу /	1	3,219.5			1	3,219.5							
Сахилгын шийтгэлийн суутгалыг орлогоор бүртгээгүй байна.	1	766.0	1	766.0									
Нярав үндсэн хөрөнгийн тайланг данс тус бүрээр бэлтгээгүй	1	-	1	-									
Нийт 12,798.2 мянган төгрөгийн ахмадын сан үүсгэсэн боловч харилцах дансанд үлдэгдлийг тайлагнаагүй	1	12,798.2	1	12,798.2									
12 дугаар сард нийт 34,980.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан боловч 3,677.0 мянган төгрөгийн хөрөнгө бүрэн хүлээж аваагүй	1	3,677.0	1	3,677.0									
Татварын тайланд 618.3 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан	1	618.3					1	618.3					
Дүн	6	21,079.0	4	17,241.2	2	3,837.8	6	21,079.0					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
5 ажилтанд 1 хоногийн томилолт илүү, 1 ажилтанд захирлын цохолтгүй, засвартай томилолтын хуудсаар томилолтын зардал бодож олгосон	1	156.0	1	156.0								
136 оюутан суралцагчдаас цахим сургалтад хамруулах зорилгоор 2,720.0 мянган төгрөг цуглуулсан боловч өөр зардалд зарцуулсан	1	2,720.0	1	2,720.0								

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэр, цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 4 зарлагын гүйлгээ, 1 орлогын гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан тус тус мэдээлээгүй	1	29,079.8			1	29,079.8	
Дүн	1	29,079.8			1	29,079.8	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүйгээс зөрүү үүссэн	1	13,816.8			1	13,816.8	
Дүн	1	13,816.8			1	13,816.8	
Нийт дүн	2	42,896.6			2	42,896.6	

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЦДАА, ЗӨРЧИМТЭЙ АСУУДЛЫН БҮРТЭЛ

№	АГАДУТ	АГАДУТ-ийн дэд анги	Ацдаа, зөрчлийн төв утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хэрх, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын холбогдох хүний Албан тушаал	Өвөг нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1. Сэнхүүгийн тайвныгн аугдтаар илрсэн ацдааны бүртгэл										
1	Урсгал зардал	Цалин	Эзэмийн амралтыг цалин хөлстэй давхардуулан олгосон байна. Илүү, дуу!	3,219,491.0	Зөвсрэн аугдтаар залруулах зөвлөмж өгсөн	Залуулсан	Залуулсан	Залуулсан	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
2	Урсгал зардал	Цалин	Сайхлын шийтгэлийн суугалгыг орлогоор бүртгэхгүй байна.	765,990.0	Зөвсрэн аугдтаар залруулах зөвлөмж өгсөн	Залуулсан	Залуулсан	Залуулсан	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
3	Тодруулга-Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Нэрээ үндсэн хөрөнгийн тайланг данс тус бүрээр балтгасгүй	-	Зөвсрөн аугдтаар залруулах зөвлөмж өгсөн	Залуулсан	Залуулсан	Залуулсан	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
4	Урсгал зардал	Мөнгөн хөрөнгө	Нийт 12,798.2 мянган төгрөгийн ахмадын сан үүсгэсэн боловч зарилцах дансанд үндэвдрийг тайлагнаагүй	12,798,271.0	Залуулсан	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Залуулах	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
5	Тодруулга-Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө	12 дугаар сард нийт 34,980.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан боловч 3,677.0 мянган төгрөгийн хөрөнгө бүрэн илгээж авчгүй	3,677,000.0	Залуулсан	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Залуулах	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
6	Урсгал зардал	Цалин	Татварын тайланд 618.3 мянган төгрөгийн цалин илүү тайлагнасан	618,250.0	Залуулсан	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Залуулах	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
Алдааны дүн				21,079,002.0						
2. Сэнхүүгийн тайвныгн аугдтаар илрсэн зөрчлийн бүртгэл										
7	Урсгал зардал	Зардал	5 ажилтанд 1 хоногийн томилолт илүү, 1 ажилтанд захирлын цололгүй, засвартай томилолтын хуудсаар томилолтын зардал бодож олгосон	156,000.0	Төлбөрийн акт тогтоох	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
8	Тусламж санхүүжилтийн орлого	Орлого	136 оюутан суралцагчдаас шахм сургалтад хамруулах зорилгоор 2,720.0 мянган төгрөг цуглуулсан боловч өөр зардалд зарцуулсан	2,720,000.0	Буцаан олгох төлбөрийн акт тогтоох	2023.02.16-ны өдрийн №22 албан ёсоор тайлбар яруулсан.	Буцаан олгох төлбөрийн акт тогтоох	Буцаан олгох төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
9	Урсгал зардал	Шатахуун	Жолоочийн тооцооны худалд явсан ирсэн зай тодорхойгүй, норм хэтрүүлсэн, спидометрийн заалт даахарагдсан, анхан шатны баримтгүй нийт 1,470.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан	1,470,414.0	Төлбөрийн акт тогтоох	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
10	Тусламж санхүүжилтийн орлого	Орлого	136 оюутан суралцагчдаас нэг хүний 90.0 мянган төгрөг нийт 12,240.0 мянган төгрөгийг төлбөр хурааж, даалганы хуацаа худалдан авсан ба нэмэлт санхүүжилтийн дансаар оруулж зарцуулсан	12,240,000.0	Буцаан олгох төлбөрийн акт тогтоох	2023.02.16-ны өдрийн №22 албан ёсоор тайлбар яруулсан.	Буцаан олгох төлбөрийн акт тогтоох	Буцаан олгох төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
11	Урсгал зардал	Цалин	НДШ-ийн тайланд 825.4 мянган төгрөгийн цалин илүү тайлагнасан	825,400.0	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
12	Урсгал зардал	Зардал	Тооцооны дансаар дамжуулаагүй, орлогод авчгүй, 24 зарлагын гүйцээж, цууд зардал бүртгэсэн	14,311,200.0	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
13	Нийт орлого	Орлого	Байр болон залын турсэгийн орлогыг бүртгэхдээ гэрээний дагуу авлага үүсгэхгүй, хүлээн авсан мөнгөн дунгаар орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн	26,298,000.0	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
14	Тодруулга-Бараа материал	Бараа материал	Байгууллагын үйл ажиллагаанд ашигласан болон амжилтад түгээн хуваарилсан хангамжийн материалыг дансанд бүртгэлтэй 191 нэр төрлийн бараа материалыг зардалаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн	-	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
15	Тодруулга-Бараа материал	Шатахуун	Жолоочийн тооцооны худалд туралн байгууллагын автомашин нь ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг бичээгүй	-	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
Зөрчлийн дүн				60,021,014.0						
3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл										

16	Шилэн данс	Шилэн данс	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэр, цагийн зардалас бусад 5-н сая төгрөгөөс дээш 4 зарчлын гүйлгээ, 1 орлогын гүйлгээ, худалдан авах амлалгааны тайлан тус тус мэдээлэгч	29,079,800.0	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
17	Зардал	Худалдан авалт	Зарчлын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгалауяагаар зөрүү үүссэн	13,816,777.0	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
18	НББ, тайлангал, Шилэн данс	НББ, тайлангал, Шилэн данс	НББ тайлангал хангалтгүй, шилэн данс, цахим бүртгэлийн системийн алдаа зөрчлийг давтан гаргасан тул нягтлан бодогчид харилцлага тооцуулах	-	Самилын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Самилын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөх	Самилын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ш.Отгонжаргал, Т.Халиунаа
3. Нийцлийн аудитын асуудлын дүн				42,896,577.0						
Нийт алдаа, зөрчлийн дүн				123,996,593.00						

Балтгэсэн, Аллах аудитор
Хянасан: Аудитын мөхөөр
Хянасан: Дарга, Тэрүүлэх аудитор

Г.Б.Ахтүвш / Огноо: 2023.02.09
Г.Наранбаяр / Огноо: 2023.02.09
Г.Б.Сарангуа / Огноо: 2023.02.09

421774454
УСА0069019049

Тамгацаж, зөвшөөрсөн:
Дарга / Ш.Отгонжаргал /
Нягтлан бодогч / Т.Халиунаа /

ПОЛИТЕХНИК
Т.Б.СББ : 461103
КОМПЛЕКТБАДУУГ

Огноо: 2023.02.09